

**XX ЗУУНД МОНГОЛ ХЭЛЭНД НУТАГШСАН
ХАРЬ ҮГС, ТЭДГЭЭРИЙН УЛС ТӨР, НИЙГЭМ, СОЁЛЫН ҮНДЭС**

Ц.Марсар*

Монголчууд эрт дээр үеэс дэлхийн улс түмнүүдтэй холбоо харилцаатай байж зуун зууны түүхэндээ нийгэм–соёлын өргөн цар хүрээтэй ажил үйл эрхэлж ирсэн нь монгол хэл харь үгээр баяжих нэгэн сэжүүр болж байсны жишээг орчин цагийн монгол хэлний үгийн сангийн бүтэц бэлхнээ харуулдаг билээ. Судлаачдын тогтоосноор орчин цагийн монгол хэлэнд араб, англи, герег, герман, орос, латин, уйгур, төвд, перс, санскрит, хятад, франц, киргиз, япон зэрэг гуч орчим хэлний үг байна. Энэ нь эдгээр хэлтэн улс орнуудтай монголчууд өргөн хэлхээ холбоотой байсны ул мөр, мөн монгол хэл өөрөө харь үг нутагшихад нээлттэй бөгөөд таатай тогтолцоотой гэдгийн нотолгоо юм.

Бидний төсөөлөхөд ямарваа хэлэнд харь үг нутагших хоёр гол хүчин зүйл байна. Нэгд тухайн хэлний авиа зүйн байгууламж харь үгийг нутагшуулах эсэх, нутагшуулах аваас авиа дуудлагын ямар өнгө төрхтэй болгох нөхцөл боломжтой, хоёрт харь үг үгийн сангийн үүргээ хадгалан үлдэх нийгэм–соёлын үндэс байгаа эсэх тухай ойлголт юм.

Бид энэ сэдвийн хүрээнд XX зуунд монгол хэлэнд нутагшсан харь үгсийн нийгэм–соёлын үндсийн талаар цухас өгүүлэхийг зорив.

Аливаа хэлэнд орж буй харь үг өөрийн нийгэм–соёлын үндэстэй. Энэхүү нийгэм–соёлын үндсийг бүрдүүлэгч гол хөрс нь тухайн улс орнуудын соёл хоорондын харилцаа байдаг. Өнөөдөр даяарших үйл явц эрчтэй өрнөх боллоо. Улс орнууд хэлхээ холбоогоо дэлхийн цар хүрээнд өргөсгөх сонирхол улам бүр давамгайлах болов. Иргэншил, соёлын нөлөөгөө тэлэх эрмэлзэл нь үндэсний хүчин зүйл, язгуур мөн чанар гэхээсээ илүү хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйл, янз бүрийн соёлын нийлэмжид тулгуурласан үнэт зүйлийн шинэ маягийн бүрдлийг чухалчилах болж байна. Сүүлийн үед их ярих болсон “tolerance” буюу тэвчих үзэл үүний нэг нотолгоо мөн.

Үүнтэй холбоотой үндэсний шинжээ эвдэхгүй байх, өв соёлоо дээдлэх, язгуур мөн чанараа хадгалах гэсэн үндэсний соёлын дотоод эрмэлзэл нь гадаад соёлын түрэлтэд нээлттэй байх, үндэсний өвөрмөц төрхөө шинэ агуулгаар баяжуулах, нийтийн хэрэглээний соёлын элементүүдийг “дэвшилийн гүүр” гэж үзэх сөрөг үзэл урсгалуудтай ямагт тулгарах боллоо. Цаашдаа ч мэдээж ийм л байх бөгөөд энэ нь хүн төрөлхтөний хөгжлийн нийтлэг жам биз ээ. Үндэсний соёл амьд, органик шинжтэй. Зүйрлэж хэлбэл тэжээгдэх эх үүсвэр, нөхөрлөх түнш, нөлөөлөх объектоо тэр өөрөө сонгох бөгөөд

* МУБИС-ийн Монгол судлалын сургууль.

тэрхүү сонголтоос нь харин ухрах дэвших, уруудах дэвжихийн олон шижим үүднэ. Соёлын харилцааны идэвхтэй үйлийн ийм шинжийг “харь соёлын нөлөө”, “соёл хоорондын нөлөө”, “гадны нөлөө” гэх мэт томъёолдог ба ийм нөлөөний хамгийн тод ул мөр бол үндэсний хэлэнд орж суурьшсан харь үг байдаг. Хэрэв асуудлыг энэ өнцгөөс нь авч үзвэл монгол хэлэнд нутагших харь үгийн ирээдүй өргөн утгаараа монгол соёл “хэнтэй хэрхэн нөхөрлөхөөс” нэн тэргүүнд шалтгаалах болно. Үүнийг бид хэлний хөгжлийн түүх болон XX зуунд монгол хэлэнд нутагшсан харь үгсийн хэрэглээний байдлаас тодорхой харж байна. Жишээ нь XIY-XII зуунд буддын соёл өргөн дэлгэрч байх үед монгол хэлэнд нутагшсан авьяас, бадаг, бурхан, лагшин, увдис, хөрш, цадиг, цонх, шарил, эрлэг зэрэг үгийг одоо язгуур монгол үгсээс ч ялган танихын аргагүй.

XX зууны монголын нийгмийн амьдралын онцлог бол ёвроп соёл иргэншил бүхий нийгмийн байгуулалд тулгуурласан соёл хоорондын харилцаа байв. Нийгмийн байгууллын тогтолцооноосоо хамааран энэхүү соёл хоорондын харилцаанд хамгийн их нөлөөтэй нийгэм-соёлын хүчин зүйл нь орос хэл, соёл байсан юм. Ийм учраас орос хэлнээс болон орос хэлээр дамжин монгол хэлэнд нутагшсан үг энэ үед илэрхий давамгайлдаг. Одоо ч гэсэн энэ суваг ажилласаар байгаа ба энэ нь монгол, орос хэл мэдээлэл, харилцааны харьцангуй өргөн шижмээр түүхийн харьцангуй урт хугацаанд холбогдсоны илрэл болж байна. Орос хэлнээс буюу орос хэлээр дамжин орж ирсэн үгс монгол хэлэнд суурьшихдаа хэлний хөгжлийн зүй тогтлыг тусгасан дараах хэдэн онцлогтой байна.

1. Монгол хэлэнд орж ирж буй харь үгсийн нутагших нэг шинж бол үйл үг болж хэлбэрших хандлага бөгөөд үүнийг XX зуунд орос хэлнээс орж ирсэн үгсийн дотроос түгээмэл ажиглаж болно. “Жижүүр” гэдэг үг (орос хэлний “*дежурный*”) монгол ахуй амьдралд урьд нь байгаагүй шинэ алба үүсч хэвшсэн нийгэм-соёлын үндэстэй. Энэ үг одоо дан үйлийн болон хам үйлшлийн “*жижүүрлэх*”, “*жижүүр хийх*”, “*жижүүрт гарах*”, “*жижүүрээс буух*” зэрэг идэвхтэй хэлбэрүүдтэй. Энэ мэтээр залийндах (заливать), занимаалдах (заниматься), очирлох (очередь), чагнаалдах (сигнал), данхраадах (домкрат), тоочиглох (точка), халтуурдах (халтурить), обойдох (обои), борнойдох (бороной), гачаадах (качать), балаанслах (баланс), соортолох (сорт), ноольлох (ноль), эрээслэх (рейс) зэрэг олон үг ийнхүү монгол үйл үгийн нэгэн адил хэрэглэгдэх болжээ. Орчин үед англи хэлнээс орж ирж буй харь үгсийн дунд ч ийм дүр зураг ажиглагдаж байгааг атгачлах, чатлах, скайнардах, канондох, шоудах зэрэг үгээр төлөөлүүлэн хэлж болно.
2. Харь үг нутагших өөр нэг сонин үзэгдэл бол хэлц үг, өвөрмөц хэллэг бүтээхэд оролцох явдал бөгөөд ийм баримт олныг дурдаж болно. Жишээ нь жижүүр гэдгээс “*жижүүрийн хэдэн үг*” (байнгын хэлдэг үг), хаазлах (газ) гэдгээс “*хаазлаж байгаад яваад өгөх*” (уурлах, цовхчих, загнах), гапий (копейка) гэдгээс “*гапий мөнгөгүй*”, “*улаан гапий ч байхгүй*” (сохор зоос ч үгүй), нооль гэдгээс “*ноольлох*”, “*нооль заах*” (байгаагаа дуусах), “*ноолийн ногоон тэг*” (усан тэнэг), данхраад гэдгээс “*данхраадуулах*” (бусдын хүчээр албан тушаалд зүтгүүлэх), “*данхраадтай хүн*” (дээрээ татлагатай хүн), метр гэдгээс “*газар метрлэх*” (найгалах, удаан явах), “*гудамж метрлэх*” (ажилгүй сэлгүүцэх) зэрэг хэлц утга үүссэн байдаг. Үүнээс гадна харь үг этгээд хэллэг, хар ярианы аялга үгийн хэлбэрээр ч түгээмэл хэрэглэгдэж байгаагийн жишээ залийндах (архичдын ярианд: сэргээх, спиртэн бүтээгдэхүүнээр организмыг дэмжих

гэсэн утгатай), хороотоглох (короткое замыкание гэдгээс үүсэлтэй, хайр сэтгэлийн холбоог егөөдөж хэлсэн утгатай) зэрэг үгнээс тодорхой харагдана.

3. XX зуунд орос хэлнээс орж ирсэн олон үг утга дүйцэх монгол үг байсаар атал хэрэглээнээс гарахгүй байгаагийн шалтгааныг тухайн үгийн нийгэм-соёлын суурьт ялгарах онцлог байгаагаар тайлбарлууштай юм. Тухайлбал хонгил гэхээсээ илүү корьдоор (коридор), бүхээг гэхээсээ хавийнк (кабина), бичгийн ширээг остоол (стол), онгоц гэхээсээ ваан (ванна), өвчний түүхийг истоор (история болезни), тэнцэл гэхээсээ балаанс, залуур, жолоо гэхээсээ рүүл (руль), шарах шүүгээг пээч (печь), галт тэргийг вогаан (вагон), суурийг хундаам (фундамент), зуурмагийг бетоон (бетон), тариан талбайг пооль (поле), уурын зуухны галчийг гачгаар (кочегар), орцыг подъез (подъезд), хайнцахыг ничээ (ничья) гэх мэтээр хэрэглэх нь түгээмэл байна. Энэ мэт олон үгийн монгол хувилбар үндсэндээ албан ярианд хэрэглэгдэх төдийхнөөр хязгаарлагдаж ярианы хэлэнд харь үг нь зонхилсоор байгаа юм.
4. Орос хэлнээс монгол хэлэнд суурьшин хэрэглэгдэж байсан олон үгийн нийгэм-соёлын үндэс устаж үгүй болсон, хувьсаж өөрчлөгдсөн шалтгаанаар тэдгээр нь одоо түүхэн үгийн эгнээнд оржээ. XX зуунд монголын нийгэм-эдийн засаг, шинжлэх ухаан, соёл, боловсролын олон салбар цоо шинээр үүсч хөгжсөн бөгөөд үүнд орос хэл, соёлын гүйцэтгэсэн үүрэг туйлын их, эдгээр салбарын хөгжил хувьсал нь түүхэн зүй тогтлынхоо дагуу явж үүнийг дагаад монгол хэлний үгсийн сангийн хувьсал ч мөн адил үргэлжилж байгааг энэ дашрамд тэмдэглэн хэлье. Жишээ нь орос хэлний *“портрет”* гэсэн үгнээс үүдэлтэй *“патиар татуулах”* хэмээх ойлголт гэрэл зургийн технологийн хөгжлөө дагаад нэгэнт хуучирчээ. Тэр бүү хэл тун саяхан ерээд оны дундуур хэрэглэгдэж байсан пейжер (англи хэлний pager) хэрэглээнээс гарснаар нэр нь мөн түүхэн үг болж хоцров. Ийм хуучирсан харь үгс салбар салбарын мэргэжлийн үг хэллэгт нэн олноор тааралдах ба бүр зарим түгээмэл хэрэглээний үг ч гэсэн хол мартагдсаныг доовтор (доктор буюу эмч), саньтаар (санитар буюу сувилагч), хомуун (комунн буюу хамтрал) зэргээс харж болно.
5. Урлаг, спорт болон мэргэжлийн чанартай олон үг тухайн ажил үйлийн хүрээнд хэрэглэгдэж байснаа үл мэдэгдэм байдлаар дэлгэрсэн байх нь олонтаа байх ба зарим нь монгол үгийн төрхийг олж танигдах аргагүй болсон байна. Жишээ нь *“жартаа”* хэмээх хүүхдийн тоглоомын нэр *“черта”* гэдэг орос үгнээс үүссэн боловч одоо хүүхдийн хэрэглээнд ердийн монгол үг мэт болжээ. Гарал үүслийн түүхээрээ нэн тодорхой бөгөөд одоо хэр нь ярианы хэлэнд түгээмэл хэрэглэгдэж буй орос үг бол *“но”* (*“харин”*, *“гэвч”* гэсэн утгатай найруулгын холбоос) гэдэг үг. Тайлангийн хурлын гол илтгэгч эхлээд ажлын амжилтын талаар ярьж, дараа нь *“но”* холбоосоор зогсоц хийгээд доголдол, дутагдлаа ярьдаг учир зүйн дараалал орос хэлнээс монголд ирж суурьшихдаа тэрхүү *“но”*-г бүхий л дутагдлын нэр буюу гарчиг мэтээр хэрэглэж хэвшсэний үр дүнд уул үгийн утга аливаа нэгэн дутагдал, тэр дундаа бүр *“явуургүй үйл”*, *“муу явдал”* гэсэн өнгө төрхтэй болжээ. Одоо дээд удирдлагын дотор ч түгээмэл хэрэглэгдсээр байгаа *“но-той хүн”* (явдалтай хүн) гэх ойлголт үүнийг харуулна. Энэ үг бас *“но ургах”* (учир ургах, ойлгомжгүй нөхцөл байдал үүсэх), *“но илрэх”* (муу үйл нь илрэх), *“но ширүүлэх”* (дутагдлыг нь дэлгэх) гэх мэтээр хэлцийн хэлбэрүүдтэй болжээ.

Асуудлын мөн чанарыг харуулах үүднээс төлөөлөл болгож бидний энд авсан хэдэн жишээ бол соёл хоорондын өргөн харилцааны нэг л тусгал юм. Хэлний харилцан нөлөөлөл, үгийн санг баяжуулахад харь үгийн гүйцэтгэх үүрэг тэргүүтэн нь уг чанартаа бол соёл хоорондын харилцааны идэвхи, түүний гүн чанараас хамаарна. XX зууны тухайд монгол хэлний хувьд ийм нөлөөг орос хэл үзүүлсээр иржээ. Орос хэлний энэхүү нөлөөг монгол хэлний хөгжлийн эрх ашгийн үүднээс сайн, муу хоёр өнцгөөс авч үзэх үндэстэй. Муу тал гэдэгт бид найруулга, өгүүлбэр зүйн зарим сөрөг өөрчлөлтийг хамааруулж үзнэ. Энэ нь үндсэндээ орчуулгын сул талтай холбоотой юм. Тухайлбал, албан бичгийн хэл найруулгад газар авсан нэр үгийн олон тооны хэрэглээ, үйлдэгдэх хэвийн хэлбэрүүд (*“арга хэмжээ авагдаж байна”, “үйл ажиллагаа явагдаж байна”, “энэ талаар тусгай бодлого боловсруулагдаж байна”* г.м.) үүнийг тодорхой харуулна.

Харин харь үг нутагшихдаа тухайн хэлний, тухайлбал монгол хэлний авиа зүйн төрхийг олж (жартаа гэдгийн адил), хэлц үг, өвөрмөц хэллэгийн хэлбэрээр хэрэглэгдэж байгаа нь тухайн хэлний хөгжлийн талаасаа эерэг хүчин зүйл бөгөөд энэ нь аливаа хэлний үгийн сан баяжих нэг арга зам мөн. Энэхүү арга зам хэрхэн яаж хэрэгжихийг тухайн үндэстний хэл дотоод хуулиараа шийдэх магадлалтай. Нэг жишээ хэлэхэд Монгол, Хятадын хооронд нийгэм–эдийн засаг болон боловсрол соёлын харилцаа идэвхтэй өрнөөд даруй хорин жил өнгөрч байна. Гэвч энэ хугацаанд (өмнөх түүхэнд бол олон хятад үг монгол хэлэнд нутагшсан) хятад хэлнээс монгол хэлэнд орж ирж суурьшсан үг олоход хэцүү. Үүний шалтгааныг бид нийгэм–соёлын хүчин зүйл талаас нь ойлгохгүй байна. Үйлдвэрлэл, технологи, бараа бүтээгдэхүүний шинэ нэр томъёо, монгол хэлэнд амар орчуулагдахааргүй ойлголтууд хятад хэлэнд олон гэдэг нь тодорхой боловч тэдгээрийг тэр бүр зээлдэж хэрэглэхгүй байгаа нь хэл–соёлын харилцаан дахь нэг сонин үзэгдэл гэлтэй. Харин англи хэлний үгс, ялангуяа олон улсын нэр томъёоны үүргээр хэрэглэгддэг олон үг монгол хэлэнд нутагших магадлал өндөр байна. Гэвч үйл явцыг урьдаас дүгнэж хэлэх одоохондоо эрт юм.

РЕЗЮМЕ

Современная все более очевидная тенденция мирового развития к глобальному сообществу, возрастающая потребность народов в расширении коммуникации в мировом масштабе со всей вероятностью ставят проблему обособления, и в некотором роде даже формирования межкультурных ценностей, без которых могут быть невозможны плодотворные, долговечные взаимоотношения между теми или иными этническими группами. Сегодня однозначно признается тот факт, что взаимоотношения народов базируются прежде всего на коммуникации культур этих же народов, в результате чего происходит *“межкультурный диалог”*. Поэтому под взаимодействием культур следует понимать особый вид непосредственных отношений, а также тех влияний и взаимных изменений, которые проявляются в ходе этих отношений, будь это область экономики или государственного устройства, образования или собственной культуры. Интересную историю в этом плане имеет межкультурный диалог между Монголией и Россией, который, конечно, можно оценить по-разному, исходя из различных временных или пространственных ориентиров. Особо благоприятным для монгольской культуры в отношении русской

был период после второй мировой войны, когда для обеих культур утвердились не только единые идеологические постулаты, но и прочные ценностные ориентации, по которым воспитывалось целое поколение, формировались взгляды людей. Данный период, который продолжался до конца разрушения социализма, существовавшего в определенное время как единая социокультурная целостность, оставил глубокие следы и в языке, которые также оценивают сегодня с точки зрения и положительной, и негативной.

Вопрос о взаимовлиянии разных культур—часть общей проблемы взаимоотношений народов. Это также вопрос об отношении того или иного народа к чужому историческому опыту, его усвоению или неприятию. Национальный язык является одной из существенных структур, которая могла бы свидетельствовать о том, насколько был активен межкультурный диалог, то есть по сравнению с национальным самосознанием, менталитетом народа или с духовным климатом той или иной эпохи, национальный язык оставляет глубокие, относительно реальные следы межкультурной коммуникации, свидетельством чего являются иллюстрированные в статье примеры заимствованных в монгольский язык русизмов в XX веке.

НОМ ЗҮЙ

Монгол хэлээр:

- Адьяа О. (2008) *Орчуулга: онол, турилага, сургамж*. Улаанбаатар.
Балжинням Н. (2008) *Монгол хэлний гадаад үгийн толь*. (Монгол-орос-англи), Улаанбаатар.
Нансалмаа Н. (2005) *Үгийн сан судлал*. Улаанбаатар.
Пүрэв-Очир Б. (2005) *Монгол хэлний эхийн өгүүлбэрзүй*. Улаанбаатар
Сатымова Ш.Т. (2006) *Монгол-киргиз ижил язгууртай үгсийн толь бичиг*. Улаанбаатар.

Орос хэлээр:

- Бахтин М.М. (1990) *Творчество Франсуа Рабле и народная культура средневековья и Ренессанса*. Москва,
Бахтин М.М. (1979) *Проблемы поэтики Достоевского*. Москва
Культорология. (1998) *XX век. Энциклопедия*. СПб.
Львовская З.Д. (2007) *Современные проблемы перевода*. Москва
Монголоведение. (2003) Элиста
Монголоведение. (2004) Элиста
Николаева Н.С. (1996) *Япония – Европа. Диалог в искусстве. Середина XVI – начало XX века*. Москва.
Фасмер М. *Этимологический словарь русского языка (в 4-х томах)*. М., 1986
Эрдэнэмаам С. (1995) *Функционирование русского языка в Монголии (дисс.)*. Москва